

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/135/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.dornogovi.audit.mn Дорноговь аймаг 2021 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Аудитын менежер: Утас: 70523020 Аудитор:	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn У.Оюунтүлхүүр Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Т.Мөнхтогтох Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn
---	---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд байгууллагын Олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
АИТХ	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БГАУТХ	Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамж
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ДГА	Дорноговь аймаг
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ИТХТ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын секторын Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4.Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6.Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан	14
3.1.Ерөнхий зүйл	14
3.2.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3.Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	15
3.4.Материаллаг байдал	15
3.5.Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7.Шилэн дансны мэдээлэл	17
3.8.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9.Аудитын илрүүлэлт	18
Залруулсан алдаа	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж	18
3.10.Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4.Менежментийн захидал	19
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	22

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.27 № *1-С/261*

танай _____-ны № _____-т

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Ц.БАТСУГИР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн Бичгийн Дарга Ц.Батсугир

11000159

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Т.ГАН-ӨЛЗИЙ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>39,120,247.73</u>	<u>36,152,550.73</u>
33	АВЛАГА	1,771,752.00	1,572,000.00
335	Бусад авлага	1,771,752.00	1,572,000.00
3351	Байгууллагаас авах авлага	1,771,752.00	1,572,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	37,348,495.73	34,580,550.73
354	Хангамжийн материал	37,348,495.73	34,580,550.73
35410	Бичиг хэргийн материал	2,978,500.00	2,162,400.00
35420	Аж ахуйн материал	31,176,382.19	24,356,870.19
35430	Сэлбэг хэрэгсэл	1,169,500.00	3,413,800.00
35440	Түлш, шатах тослох материал	2,024,113.01	4,647,480.01
35460	Хүнсний материал	0.53	0.53
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>174,864,794.60</u>	<u>137,064,567.94</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	174,864,794.60	137,064,567.94
392	Биет хөрөнгө	169,080,937.06	132,657,592.64
39203	Авто-тээврийн хэрэгсэл	237,000,000.00	237,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(108,116,666.59)	(149,916,666.55)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	39,802,650.00	47,898,650.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(20,021,353.42)	(23,103,255.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	39,143,198.46	42,454,698.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	(18,726,891.39)	(21,675,833.99)
393	Биет бус хөрөнгө	5,783,857.54	4,406,975.30
39301	Програм хангамж	220,000.00	220,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(14,997,671.25)	(15,041,671.29)
39303	Бусад биет бус хөрөнгө	20,561,528.79	22,131,528.79
39304	Хуримтлагдсан элэгдэл	-	(2,902,882.20)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>213,985,042.33</u>	<u>173,217,118.67</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>323,197.50</u>	<u>97,049.97</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	323,197.50	97,049.97
413	Өглөг	323,197.50	97,049.97
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	323,197.50	97,049.97
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>213,661,844.83</u>	<u>173,120,068.70</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	213,661,844.83	173,120,068.70
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	68,719,077.67	68,719,077.67
51101	Өмч: - төрийн	68,719,077.67	68,719,077.67
512	Хуримтлагдсан үр дүн	144,207,025.21	103,665,249.08
51210	Өмнөх үеийн үр дүн	144,207,025.21	144,207,025.21
51220	Тайлант үеийн үр дүн	-	(40,541,776.13)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	735,741.95	735,741.95
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>213,985,042.33</u>	<u>173,217,118.67</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	943,349,080.00	2,399,262,700.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,970,800.00	1,570,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,970,800.00	1,570,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,970,800.00	1,570,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,420,900.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	549,900.00	1,570,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	941,378,280.00	2,397,692,700.96
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,021,480.00	1,262,690,273.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,241,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,021,480.00	21,690,273.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	921,356,800.00	1,135,002,427.96
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	921,356,800.00	1,135,002,427.96
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	946,288,979.34	2,437,427,657.09
21	УРСГАЛ ЗАРДАЛ	946,288,979.34	2,437,427,657.09
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	932,051,965.44	2,436,427,657.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,900,918.00	140,503,756.44
210101	Үндсэн цалин	116,958,918.00	138,571,756.44
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,942,000.00	1,932,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,783,442.60	16,945,097.99
210201	Тэтгэврийн даатгал	10,554,150.60	11,505,575.37
210202	Тэтгэмжийн даатгал	1,039,076.00	1,177,101.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	863,910.00	1,280,090.10
210204	Ажилгүйдлийн даатгал	211,709.00	271,121.43
210205	Эрүүл мэндийн даатгал	2,114,597.00	2,711,210.02
2104	Хангамж, бараа материалын зардал	35,282,786.10	31,766,047.00
210401	Бичиг хэрэг	3,198,682.00	6,060,258.00
210402	Тээвэр, шатахуун	22,634,644.10	17,902,963.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,372,231.00	4,478,805.00
210404	Ном, хэвлэл	312,000.00	132,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,621,229.00	3,048,021.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	11,844,633.00	17,200,634.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	596,000.00
210604	Урсгал засвар	11,844,633.00	16,604,634.00
2107	Томилолт, зочны зардал	9,868,400.00	4,935,799.00
210701	Гадаад албан томилолт	-	115,799.00
210702	Дотоод албан томилолт	9,868,400.00	4,820,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	489,888,975.00	1,930,986,163.00

Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	487,179,439.00	1,928,045,674.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,998,560.00	2,208,313.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,176.00	150,176.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,800.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	192,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	249,482,810.74	294,090,159.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	168,691,253.00	220,452,949.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,655,077.00	22,768,274.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,136,480.74	50,868,936.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,237,013.90	1,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,237,013.90	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,237,013.90	-
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(2,939,899.34)</u>	<u>(38,164,956.13)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,376,820.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	2,360,820.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	16,000.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	(2,376,820.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(2,939,899.34)</u>	<u>(40,541,776.13)</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	942,799,180.00	2,397,692,700.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,420,900.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	1,420,900.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,420,900.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,420,900.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	941,378,280.00	2,397,692,700.96
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	20,021,480.00	1,262,690,273.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,241,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	19,021,480.00	21,690,273.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	921,356,800.00	1,135,002,427.96
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	921,356,800.00	1,135,002,427.96
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	923,139,180.00	2,386,285,200.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	923,139,180.00	2,386,285,200.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	908,902,166.10	2,383,713,200.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	120,824,995.10	140,562,755.97
210101	Үндсэн цалин	116,168,356.10	134,354,457.97
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,656,639.00	6,208,298.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,793,596.00	16,945,095.99
210201	Тэтгэврийн даатгал	10,868,396.00	11,505,573.37
210202	Тэтгэмжийн даатгал	981,300.00	1,196,436.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	785,000.00	1,260,755.10
210204	Ажилгүйдлийн даатгал	196,300.00	271,121.43
210205	Эрүүл мэндийн даатгал	1,962,600.00	2,711,210.02
2104	Хангамж, бараа материалын зардал	38,989,142.00	35,447,715.00
210401	Бичиг хэрэг	5,557,700.00	5,330,850.00
210402	Тээвэр, шатахуун	20,266,500.00	19,674,950.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,038,613.00	4,315,913.00
210404	Ном, хэвлэл	312,000.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	144,000.00	144,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,670,329.00	5,982,002.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,828,885.00	20,068,399.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,170,000.00
210602	Тавилга	-	270,400.00
210604	Урсгал засвар	13,828,885.00	16,627,999.00
2107	Томилолт, зочны зардал	9,950,400.00	4,894,000.00
210702	Дотоод албан томилолт	9,950,400.00	4,894,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	497,575,548.00	1,927,427,712.00

Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	494,866,012.00	1,924,487,223.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	350,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,998,560.00	2,208,313.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	159,176.00	150,176.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,800.00	40,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	192,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	212,939,600.00	238,367,523.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	177,490,206.00	218,201,140.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,449,394.00	20,166,383.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,237,013.90	2,572,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00	1,000,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	11,237,013.90	1,572,000.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,237,013.90	1,572,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>19,660,000.00</u>	<u>11,407,500.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	19,660,000.00	11,407,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,660,000.00	11,407,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,660,000.00	11,407,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	19,660,000.00	11,407,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(19,660,000.00)</u>	<u>(11,407,500.00)</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=====	=====
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,719,077.67	735,741.95	147,099,424.55	216,554,244.17
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,719,077.67	735,741.95	147,099,424.55	216,554,244.17
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(2,892,399.34)	(2,892,399.34)
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,719,077.67	735,741.95	144,207,025.21	213,661,844.83
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	68,719,077.67	735,741.95	144,207,025.21	213,661,844.83
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,719,077.67	735,741.95	144,207,025.21	213,661,844.83
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(40,541,776.13)	(40,541,776.13)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,719,077.67	735,741.95	103,665,249.08	173,120,068.70

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,330,472,400.00	1,135,002,427.96	195,469,972.04	85.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,330,472,400.00	1,135,002,427.96	195,469,972.04	85.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,330,472,400.00	1,135,002,427.96	195,469,972.04	85.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	203,436,800.00	140,562,755.97	62,874,044.03	69.1
210101	Үндсэн цалин	197,628,800.00	134,354,457.97	63,274,342.03	68.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,808,000.00	6,208,298.00	(400,298.00)	106.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,429,600.00	16,945,095.99	8,484,504.01	66.6
210201	Тэтгэврийн даатгал	17,292,100.00	11,505,573.37	5,786,526.63	66.5
210202	Тэтгэмжийн даатгал	2,034,400.00	1,196,436.07	837,963.93	58.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,627,500.00	1,260,755.10	366,744.90	77.5
210204	Ажилгүйдлийн даатгал	406,900.00	271,121.43	135,778.57	66.6
210205	Эрүүл мэндийн даатгал	4,068,700.00	2,711,210.02	1,357,489.98	66.6
2104	Хангамж, бараа материалын зардал	36,112,800.00	35,447,715.00	665,085.00	98.2
210401	Бичиг хэрэг	5,584,000.00	5,330,850.00	253,150.00	95.5
210402	Тээвэр, шатахуун	19,699,000.00	19,674,950.00	24,050.00	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,316,000.00	4,315,913.00	87.00	100.0
210404	Ном, хэвлэл	312,800.00	-	312,800.00	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	180,000.00	144,000.00	36,000.00	80.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,021,000.00	5,982,002.00	38,998.00	99.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	26,303,000.00	25,154,899.00	1,148,101.00	95.6
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,040,000.00	5,040,000.00	-	100.0
210602	Тавилга	3,400,000.00	3,041,900.00	358,100.00	89.5
210604	Урсгал засвар	17,863,000.00	17,072,999.00	790,001.00	95.6
2107	Томилолт, зочны зардал	20,225,000.00	4,894,000.00	15,331,000.00	24.2
210702	Дотоод албан томилолт	20,225,000.00	4,894,000.00	15,331,000.00	24.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	797,670,000.00	692,748,712.00	104,921,288.00	86.8

Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	792,080,000.00	689,808,223.00	102,271,777.00	87.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.00	350,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	4,800,000.00	2,208,313.00	2,591,687.00	46.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	150,176.00	49,824.00	75.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	40,000.00	40,000.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	200,000.00	192,000.00	8,000.00	96.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	221,295,200.00	219,249,250.00	2,045,950.00	99.1
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,795,200.00	199,082,867.00	1,712,333.00	99.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	20,500,000.00	20,166,383.00	333,617.00	98.4
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,330,472,400.00	1,135,002,427.96	195,469,972.04	85.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,330,472,400.00	1,135,002,427.96	195,469,972.04	85.3
132001	Орон нутгийн төсвөөс	1,330,472,400.00	1,135,002,427.96	195,469,972.04	85.3
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,262,690,273.00	(1,262,690,273.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,262,690,273.00	(1,262,690,273.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	1,260,118,273.00	(1,260,118,273.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	1,241,000,000.00	(1,241,000,000.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	1,241,000,000.00	(1,241,000,000.00)
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	19,118,273.00	(19,118,273.00)
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	19,118,273.00	(19,118,273.00)
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,000,000.00	(1,000,000.00)
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,000,000.00	(1,000,000.00)
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,000,000.00	(1,000,000.00)
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	1,572,000.00	(1,572,000.00)
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,572,000.00	(1,572,000.00)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	1,262,690,273.00	(1,262,690,273.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	1,262,690,273.00	(1,262,690,273.00)
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	1,241,000,000.00	(1,241,000,000.00)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	21,690,273.00	(21,690,273.00)
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Нарийн бичгийн дарга Ц.Батсугир танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгө, хөрөнгийн устгалтай холбоотой, ГХУСАЗСЗ-ийн журмын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 21-ээс 2021 оны 01 дүгээр сарын 26–ны хооронд аудитор Т.Мөнхтогтох хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 44 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдааны үйл ажиллагааг аймгийн хөгжлийн зорилтуудыг сайтар хэрэгжүүлэхэд чиглүүлэн хүртээмжтэй зохион байгуулан, хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангуулна.
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдааны үйл ажиллагааг шуурхай хангаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хуулиар олгогдсон бүрэн эрх, үүргийн хүрээнд орон нутаг болон иргэдийн ашиг сонирхолд нийцүүлсэн бодлого боловсруулж оновчтой шийдвэр гарган ажиллана.
- Төлөөлөгч, хурлын хороодыг идэвхжүүлэн Хуралд хуулиар олгогдсон хяналт шалгалтын ажлын үр дүнг дээшлүүлэн хуулийн хэрэгжилт, аймгийн эдийн засгийн чадавхыг сайжруулахад нөлөөлж ажиллана.
- Хурлын төлөөллийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ төлөөлөгч-иргэдийн хамтын ажиллагааг сайжруулах замаар иргэдийн идэвх оролцоог дээшлүүлнэ.
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагаа, гарсан шийдвэрийг олон нийтэд шуурхай хүргэж, тэмдэглэлт өдөр, хууль тогтоомжийг сурталчлах нөлөөллийн ажлуудыг хийн хурал, иргэдийн хамтын ажиллагааг сайжруулна.
- Хурлын ажлын албаны шуурхай байдлыг ханган нутгийн өөрөө удирдах байгууллагыг бэхжүүлэхэд шаардагдах ажлыг зохион байгуулна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна.

Үүнд:

- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоол “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”;
- Засгийн газрын 2020 оны 163 дугаар тогтоол “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем нэвтрүүлэх тухай”;

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 0.2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн тайлангийн нийт зардлын 1,856,466.3 мянган төгрөгөөс 0.2 хувиар буюу 3,712.3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 1 хувь болгон өөрчилж, 24,398.0 мянган төгрөгөөр баталгаажууллаа.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40,767.9 мянган төгрөгөөр буюу 19 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	1,771.7	1,572.0	-199.7
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	37,348.5	34,580.6	-2,767.9
Үндсэн хөрөнгө	174,864.8	137,064.5	-37,800.3
Нийт хөрөнгө	213,985.0	173,217.1	-40,767.9
Өр төлбөр	323.2	97.0	-226.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	213,661.8	173,198.3	-40,463.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	213,985.0	173,217.1	-40,767.9

Авлага дансны үлдэгдэл 1,572.0 мянган төгрөг болж 199.7 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь нэмэлт дансны харилцахын үлдэгдлийг авлагаар бүртгэсэнтэй холбоотой.

Бараа материалын дансны үлдэгдэл 34,580.6 мянган төгрөг болж 2,767.9 мянган төгрөгөөр буурсан нь хагас, бүтэн жилийн эд хөрөнгийн тооллогоор ашиглалтгүй материалыг хассанаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 137,064.5 мянган төгрөг болж 37,800.3 мянган төгрөгөөр буурсан байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 11,407.5 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 1,570.0 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Өр төлбөр дансны 97.0 мянган төгрөгийн өглөг нь цалин, ХХОАТ-ын өглөг бөгөөд 226.2 мянган төгрөгөөр буурсан нь цалингийн өглөгөөс хасагдсан байна.

Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,455,913.6 мянган төгрөгөөр буюу 154 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж цагаатгагдсан нөхөн олговор, орон нутгийн төсвийн санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 1,491,138.6 мянган төгрөгөөр буюу 157 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс 19,567.7 мянган төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардал 5,356.0 мянган төгрөг, БГАҮТХ 1,441,097.2 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 44,564.2 мянган төгрөгийн зардлууд байна. Энэ нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал, төлөөлөгч нарын тойрогтоо хийх ажлын зардал нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,134,287.1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,134,287.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 196,185.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,330,472.4 мянган төгрөгөөр баталсан байна. Тодруулбал: цалин хөлсийг 55,207.1 мянган төгрөг, БГАҮТХ-ийг 140,218.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,330,472.4 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,330,472.4 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,135,002.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,135,002.4 мянган төгрөгийг зарцуулж 195,469.9 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,135,002.4 мянган төгрөг буюу 85 хувьтай байгаа нь дотоод албан томилолтын зардлыг 15,331.0 мянган төгрөгөөр, мэдээлэл сурталчилгааны зардлыг 10,490.0 мянган төгрөгөөр, ИТХ-д суудалтай намын санхүүжилтийн зардлыг 68,000.0 мянган төгрөгөөр, төлөөлөгчдийн тойрогтоо хийх зардлыг 22,983.5 мянган төгрөгөөр тус тус дутуу хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Орлогын төлөвлөгөө байхгүй.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 1,000.0 төгрөг үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1,261,690.2 мянган төгрөг, нийт 1,262,690.2 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Олон нийтийн цагдаа нарын урамшуулалд 20,480.2 мянган төгрөг, Цагаатгалын ажлыг удирдан зохион байгуулах комиссын газраас цагаатгалын нөхөн олговорт 1,241,000.0 мянган төгрөг, АЗДТГ-аас 2019 оны “Шилдэг аймаг” болсонтой холбоотой 1,000.0 мянган төгрөг, тендерийн баримт бичгийн 210.0 мянган төгрөг, нийт 1,262,118.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,572.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож мэдээлсэн мэдээлэл байхгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 7,516.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлагын 2 албан шаардлагыг биелүүлээгүй байна. Аудитаар өгсөн 126.1 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 50 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-	-	-
Албан шаардлага	3	7,516.9	1	7,516.9	2	-	67
Зөвлөмж	2	126.1	1	70.1	1	56.0	50
Нийт дүн	5	7,643.0	2	7,587.0	3	56.0	58

/мянган төгрөг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 440,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 440,000.0 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 2 албан шаардлага хүргүүлж, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. 2020.06.30-ны санхүүгийн тайлангаар Нэмэлт санхүүжилтийн орлогын эх үүсвэрийг ЗДНХ түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөд 440.0 сая төгрөгөөр дутуу бүртгэснийг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 2 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Өмнөх аудитаар эрхзүйн үндэслэлгүйгээр аймгийн ИТХ-д суудалтай намд дэмжлэг гаргаж байгаа зөрчлийг зогсоох, төсөв батлахгүй байх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд ИТХ-д суудалтай намын санхүүжилтэд 300.0 сая төгрөгийн зардлыг дахин баталж, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 22 дугаар зүйлийн 22.5 “төсвийн ангиллын зүйлд санаатайгаар буруу мэдээлэл оруулж төсвийн орлого, зарлагын хэмжээг өөрчлөхийг хориглоно”, Улс төрийн намын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 “Улсын Их Хуралд суудал бүхий намд түүний авсан суудлын тоогоор Улсын Их Хурлын гишүүний нэг суудлыг жилд арван сая төгрөгөөр тооцож, Улсын Их Хурлын тухайн бүрэн эрхийн хугацаанд улирал тутам улсын төсвөөс санхүүжилт олгоно. Энэхүү санхүүжилтийн 50 хувийг Улсын Их Хурлын гишүүдийн сонгуулийн тойрогт явуулах үйл ажиллагаанд зарцуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Тээвэр шатахууны зардалд харьцуулалтын аргыг ашиглахгүйгээр шууд худалдан авалтыг хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 “харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар”, 33 дугаар зүйлийн 33.1 “бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно”, Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 “төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1 Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Бага үнэтэй түргэн элэгдэх, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас нийт 4.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, холбогдох дүрэм журам мөрдөгдөхгүй байх.

1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын бага үнэтэй түргэн элэгдэх – 210406, урсгал засвар – 210604, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ – 210801 гэсэн заалттай нийцэхгүй байна.

Бага үнэтэй түргэн элэгдэх, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас хөрөнгө бэлтгэхгүй байх.

2 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

2.1 Илрүүлэлт:

Нийт төсвийн гүйцэтгэл 1,135.0 сая төгрөг буюу 85.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан бөгөөд 195.5 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Материаллаг хэмжээний цалин хөлс 62.9 сая төгрөг, НДШ 8.5 сая төгрөг хэмнэгдсэн нь нягтлан бодогч 1 хүний орон тоо дутуу ажилласан гэсэн тайлбарыг ирүүлсэн, гэвч энэ нь төлөвлөлт буруу хийгдсэнтэй холбоотой байна. Дотоод томилолт 15.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь ковид-19 цар тахал, томилолтын зардлыг 2020.04.01-10.01-ний өдрийг хүртэл зогсоосонтой холбоотой байна. Мэдээлэл сурталчилгааны зардал 10.5 сая төгрөг хэмнэгдсэн төлөвлөлт буруу хийгдсэнтэй холбоотой байна. ИТХ-д суудалтай намын санхүүжилт 68.0 сая төгрөг, төлөөлөгч тойрогтоо хийх ажлын зардал 22.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Засгийн газрын 2020 оны 114, 168-р тогтоолын дагуу чухал шаардлагатай зардлуудыг санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

2.2 Эрсдэл:

Төсвийн тухай хууль тогтоомж зөрчигдөх, төсвийн хөрөнгө үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй, зориулалт бусаар зарцуулагдах.

2.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

2021 оны төсвийг өмнөх жилүүдийн гүйцэтгэл, Төсвийн тухай хуульд заасан заалтын дагуу төсвийг бодитой боловсруулж, батлуулах.

3 Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт үр дүн

3 Зардлын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Албан хэрэгцээнд ашиглаж буй 2 авто машинд Өмч хамгаалах зөвлөлөөр уг засвар үйлчилгээг зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх үндэслэлийг тогтоож, авч хэлэлцэж шийдвэрлээгүй 14.6 сая төгрөгийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл худалдан авсан байна. Мөн АИТХ-ын даргын нөөц хөрөнгөнөөс 10.6 сая төгрөгийн гарын бэлэг, мөнгөн аяга, хоол, зочид буудлын хөлс, 28.5 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэж, нийт 39.1 сая төгрөгийн төсвийг хэмнэлтгүй зарцуулсан байна.

3.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үрэлгэн байдлаар зарцуулагдах, автомашины засвар үйлчилгээнд тавих хяналт сулрах, холбогдох хууль эрхийн акт зөрчигдөх.

3.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар баталсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар” 210910 “Орон нутгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд зарцуулагдах нөөц хөрөнгийг энэ ангилалд бүртгэн, төлөвлөлт, гүйцэтгэлийг хуулийн дагуу зарцуулагдах зориулалтаар гаргана”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай” тушаалын 5 дугаар хавсралт “Автомашины сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаар норм”-той нийцэхгүй байна.

Автомашины эвдрэл гэмтлийг анхан шатны баримтаар нотолж байх, Мөн АИТХ-ын даргын нөөц хөрөнгөд төсөв батлахгүй байх, зайлшгүй шаардлагатай зардлыг байгууллагын зардлын төсөвт холбогдох эдийн засгийн ангиллаар нь оруулж баталж байх.

4 Удирдлагын дээд болон дотоод хяналт

4.1 Илрүүлэлт:

ИТХ-ын нарийн бичгийн даргын 2020.12.21-ний А/49 дүгээр тушаалаар 2.2 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг акталж, устгах тушаал гарч данс бүртгэлээс хассан боловч хөрөнгийн устгал хийгээгүй байна.

4.2 Эрсдэл:

Холбогдох хууль журам мөрдөгдөхгүй байх, хувьдаа завших.

4.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 засаж “сэлбэн ашиглах боломжгүй эд хөрөнгийг акталж устгах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Байгууллагын данс бүртгэлээс хассан хөрөнгийг акталж, устгал хийх.

5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

5.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг шүүж үзэхэд байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 4 нэр төрлийн 49 ширхэг 64.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байна.

5.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, дансны үнэ бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү үүсэх.

5.3 Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 “илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Ашиглах боломжтой боловч ашиглалтын хугацаа дууссан хөрөнгийг үнэлж бүртгэх, шаардлага хангаагүй хөрөнгийг акталж данснаас хасах арга хэмжээ авч ажиллах.

6 Тухайн байгууллага, салбартай холбоотой хууль эрх зүйн орчин

6.1 Илрүүлэлт:

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль шинэчлэгдэж 2020.01.01-ний өдрөөс дагаж мөрдөгдөж эхэлсэн. Гэтэл аймгийн ИТХТ-ийн 2016 оны 33 дугаар тогтоолоор баталсан журмыг шинэчлэн боловсруулаагүй байна.

6.2 Эрсдэл:

Шинэчлэн батлагдсан хууль мөрдөгдөхгүй байх.

6.3 Өгсөн зөвлөмж:

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуультай нийцэхгүй байна.

ИТХТ-ийн 2016 оны 33 дугаар тогтоолоор баталсан журмыг шинээр батлагдсан Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуультай нийцүүлэн шинэчлэн боловсруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Дорноговь аймгийн ИТХ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02			ДГА-2021/135/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал		мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Бага үнэтэй түргэн элэгдэх, урсгал засвар, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас нийт 4.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна	4,849.0	Зөвлөмж	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Ц.Батсугир Б.Наранцацрал
2	Нийт төсвийн гүйцэтгэл 1,135.0 сая төгрөг буюу 85.3 хувийн гүйцэтгэлтэй гарсан бөгөөд 195.5 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Материаллаг хэмжээний цалин хөлс 62.9 сая төгрөг, НДШ 8.5 сая төгрөг хэмнэгдсэн нь нягтлан бодогч 1 хүний орон тоо дутуу ажилласан гэсэн тайлбарыг ирүүлсэн, гэвч энэ нь төлөвлөлт буруу хийгдсэнтэй холбоотой байна. Дотоод томилолт 15.3 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь ковид-19 цар тахал, томилолтын зардлыг 2020.04.01-10.01-ний өдрийг хүртэл зогсоосонтой холбоотой байна. Мэдээлэл сурталчилгааны зардал 10.5 сая төгрөг хэмнэгдсэн төлөвлөлт буруу хийгдсэнтэй холбоотой байна. ИТХ-д суудалтай намын санхүүжилт 68.0 сая төгрөг, төлөөлөгч тойрогтоо хийх ажлын зардал 22.9 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Засгийн газрын 2020 оны 114, 168-р тогтоолын дагуу чухал шаардлагатай зардлуудыг санхүүжүүлсэнтэй холбоотой байна	-	Зөвлөмж	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Ц.Батсугир Б.Наранцацрал
3	Албан хэрэгцээнд ашиглаж буй 2 авто машинд Өмч хамгаалах зөвлөлөөр уг засвар үйлчилгээг зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаарх үндэслэлийг тогтоож, авч хэлэлцэж шийдвэрлээгүй 14.6 сая төгрөгийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэл худалдан авсан байна. Мөн АИТХ-ын даргын нөөц хөрөнгөнөөс 10.6 сая төгрөгийн гарын бэлэг, мөнгөн аяга, хоол, зочид буудлын хөлс, 28.5 сая төгрөгийн хөрөнгийг бэлтгэж, нийт 39.1 сая төгрөгийн төсвийг хэмнэлтгүй зарцуулсан байна.	-	Зөвлөмж	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Ц.Батсугир Б.Наранцацрал
4	ИТХ-ын нарийн бичгийн даргын 2020.12.21-ний А/49 дүгээр тушаалаар 2.2 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийг акталж, устгах тушаал гарч данс бүртгэлээс хассан боловч хөрөнгийн устгал хийгээгүй байна	-	Зөвлөмж	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Ц.Батсугир Б.Наранцацрал

Дорноговь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

5	Үндсэн хөрөнгийн үлдэгдлийг шүүж үзэхэд байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 4 нэр төрлийн 49 ширхэг 64.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгө байна.	-	Зөвлөмж	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Ц.Батсугир Б.Наранцацрал
6	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль шинэчлэгдэж 2020.01.01-ний өдрөөс дагаж мөрдөгдөж эхэлсэн. Гэтэл аймгийн ИТХТ-ийн 2016 оны 33 дугаар тогтоолоор баталсан хүчингүй болсон хуулийн заалтыг мөрдөж ажилласан байна.	-	Зөвлөмж	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Ц.Батсугир Б.Наранцацрал
7	Өмнөх аудитаар эрхзүйн үндэслэлгүйгээр аймгийн ИТХ-д суудалтай намд дэмжлэг гаргаж байгаа зөрчлийг зогсоох, төсөв батлахгүй байх албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, тайлант онд ИТХ-д суудалтай намын санхүүжилтэд 300.0 сая төгрөгийн зардлыг дахин баталж, зарцуулсан байна	-	Албан шаардлага өгөх	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Ц.Батсугир Б.Наранцацрал
8	Тээвэр шатахууны зардалд харьцуулалтын аргыг ашиглахгүйгээр шууд худалдан авалтыг хийсэн байна.	-	Албан шаардлага өгөх	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Ц.Батсугир Б.Наранцацрал
9	2020.06.30-ны санхүүгийн тайлангаар Нэмэлт санхүүжилтийн орлогын эх үүсвэрийг ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөд 440.0 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	440,000.0	Залруулга	Нарийн бичгийн дарга Нягтлан бодогч	Ц.Батсугир Б.Наранцацрал
ДҮН		444,849.0		-	